



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/731

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8\04 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8\04 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтанд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 2.2 дахь заалт, Дөргөн суманд хийгдэх “ Иоджуулсан давсны үйлдвэрийг дэмжих” ажлын 44.000.000 төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Дөргөн сумын Засаг дарга Т.Заяад шилжүүлсүгэй.
2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хүлээлгэн өгөх, хэрэгжилтийг хангах, арга хэмжээг тайлагнахыг Дөргөн сумын Засаг дарга Т.Заяад даалгасугай.
3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганданповрон, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДУГЭРЖАВ

02-02586
Zax A/731 Ch